

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

Хоёр. Хөтөлбөрийн зарчим

2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална:

2.1.1.залуучуудыг эх орныхоо өнөө ба ирээдүйн хөгжилд чухал үүрэгтэй нийгмийн бүлэг гэж үзнэ.

2.1.2.залуучууд нас, хүйс, арьс өнгө, боловсрол, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл, оюун ухаан, бие махбодын чадвараар ялгаварлан гадуурхагдахаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалахад төрийн бодлого чиглэгдэнэ.

2.1.3.залуучууд нийгмийн бүхий л хүрээнд эрх тэгш боломжоор хангагдана.

2.1.4.хөтөлбөр нь “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилтуудтай нягт уялдаатай байна.

2.1.5.залуучуудын амьдралд нөлөө үзүүлэх аливаа бодлого, шийдвэр гаргах, төлөвлөн хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд тэдний оролцоог хангана.

2.1.6.хөтөлбөрийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хууль тогтоомжийн хүрээнд салбар хоорондын уялдааг хангасан, судалгаа, баримтад үндэслэсэн, залуучуудын бодит хэрэгцээ, тэргүүн туршлагад тулгуурлана.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

3.1.Хөтөлбөрийн зорилго нь залуучуудыг нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх замаар өөрийн, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх, үүргээ ухамсарладаг өрсөлдөх чадвартай иргэн болоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

3.2.Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ.

3.2.1.залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх¹;

¹ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 10.1.2 заалтыг үндэслэв

3.2.2. боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулах;

3.2.3. залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

3.2.4. нийгмийн амьдралд залуучуудын оролцох оролцоог сайжруулах;

3.2.5. залуучуудад нийгмийн дэмжлэг үзүүлэх;

3.3. Хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1. Залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.1. Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр эрүүл амьдралын зан үйлийг сурталчилж, залуучууд бие бялдраа чийрэгжүүлэх, аливаа өвчлөлөөс сэргийлэх талаарх мэдээллийг тогтмолжуулна.

4.1.1.2. Эрүүл мэндийн оношилгоо, үзлэгт залуучуудыг тогтмол хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

4.1.1.3. Эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх талаар залуучуудын санаачилгыг дэмжинэ.

4.1.1.4. Залуучуудад бэлгийн зөв чиг хандлагыг төлөвшүүлэхэд олон нийтийн болон мэдээллийн хэрэгслийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.2. Залуучуудад ээлтэй эрүүл мэндийн оношилгоо, үзлэг, зөвлөгөө, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.2.1. Залуучуудад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ эрхийг нь хамгаалах талаар эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чадавхийг сайжруулна.

4.1.2.2. Оюутан, залуучуудад нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.2.3. Зорилтот бүлгийн залуучуудад эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгөх сургалтыг сайн дурын ажилтан, үе тэнгийнхэнтэй нь хамтран зохион байгуулна.

Оюутан, залуучуудад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээг тогтмолжуулна.

4.1.3. Залуучуудын дундах сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх олон нийтийн дэмжлэгийг бий болгоно.

4.1.3.1. Сэтгэцийн эрүүл мэндийн удирдлага, тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг залуучууд, олон нийтэд хүртээмжтэй болгоно.

4.1.3.2. Ажлын байран дээр стрессийн түвшин тогтоож, сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлж, залуу ажилтнуудаа тогтвортой ажиллуулах ур чадварыг удирдлагад төлөвшүүлнэ.

4.1.3.3. Залуу ажилтнууд, ажил олгогчдын дунд байгууллагадаа эерэг соёлыг төлөвшүүлэх, өөрчлөлт хийх манлайлагч байх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлнэ.

4.2. Боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулах зорилтын хүрээнд дараахь чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн залуучуудын мэдлэг, ур чадвар, хандлагын цогц чадамжийг дэмжихэд боловсролын байгууллага, ажил олгогч, олон нийтийн түншлэлийг хөгжүүлнэ.

4.2.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн багц судалгаанд² үндэслэн мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагад оюутан элсүүлэх ажил, мэргэжлийн жагсаалтыг эрэмбэлнэ.

4.2.1.2. ЕБС-ийн ахлах анги, мэргэжлийн болон дээд боловсрол байгууллагын хичээлийн хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжсэн амьдрах ухааны болон гэр бүл төлөвлөлт, жендэрийн тэгш байдлын асуудлыг тусгана.³

4.2.1.3. их, дээд сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн дэргэд оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх зорилго бүхий сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх, мэргэжлийн дадлага хийх бааз, номын сангийн чанар, хүртээмжийг сайжруулна.⁴

4.2.1.4. хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад үе тэнгийнхэнтэйгээ сурч, боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор бүх шатны сургуульд шаардлагатай боломжит тохируулга, нэмэлт хэрэглэгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.

4.2.1.5. олон нийт, залуучууд, төрийн байгууллага, хувийн хэвшлийнхэнд хүний эрх, эрх зүй, ёс зүйн талаарх мэдлэгийг тохирсон хэлбэрээр хүргэх замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, тулгамдсан асуудалд зохистой хариу арга хэмжээ авдаг болоход нь нөлөөлнө.⁵

4.2.2. Залуучууд мэргэжлийн чиг баримжаа олж авахын зэрэгцээ өөрийн онцлог авъяасаа хөгжүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засагт өрсөлдөх мэдлэг, ур чадвартай болохыг нь дэмжинэ.⁶

4.2.2.1. үе тэнгийнхнээ эрдэм ухаан, авъяас чадвараараа тэргүүлж буй залуучуудыг сургалтын хөтөлбөр, тэтгэлэгт хамруулах, өрсөлдөөнт ажлын байраар хангах ажлыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.⁷

4.2.2.2. авъяас, сурлага, урлаг, спортын амжилтаараа үе тэнгийнхнээ манлайлагч залуучуудыг урамшуулан, олон улсын хэмжээнд мэдлэг, ур чадвар, авхаалж самбаагаа сориход нь дэмжлэг үзүүлэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэн зохион байгуулна.⁸

4.2.2.3. цахим сургалтаар боловсрол эзэмших нөхцөлөөр залуу эцэг, эх, хөдөлмөр эрхэлдэг, сургууль завсардсан залуучуудыг хангаж, техник, технологийн

²Залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдлын судалгаа, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа,

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, Ажил олгогчоос ажилтанд тавих шаардлага судалгаа

³ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 6.1.4. болон 12.3.4 заалтыг үндэслэв

⁴ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.1.3. болон 12.3.1 заалтыг үндэслэв

⁵ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.1.2 болон 10.1.4 заалтыг үндэслэв

⁶ UNESCO (2014) Roadmap for Implementing the Global Action Programme on Education for Sustainable Development, Priority action area 2

⁷ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.1.2 болон 12.3.2 заалтыг үндэслэв

⁸ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.3.3 заалтыг үндэслэв

дэвшлээс суралцан, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд цахилгаан холбоо, үүрэн телефоны байгууллагуудын дэмжлэгийг авна.

4.2.2.4. малчин залуучуудад насан туршийн боловсролыг дэд бүтцийн болон зохион байгуулалтын оновчтой шийдлийг ашиглан хүртээмжтэй болгоно.

4.2.3. Өрсөлдөх давуу чадвараа ашиглан, баялаг бүтээхэд хувь нэмрээ оруулах залуучуудын үүсгэл санаачилгыг дэмжинэ.

4.2.3.1. залуучууд мэргэших, техник, технологийн дэвшил гаргах, инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд зориулсан залуу судлаачдын үндэсний тэтгэлэгт хөтөлбөрийг өргөжүүлнэ.⁹

4.2.3.2. залуучуудын тулгамдсан асуудлыг судлах ажлыг залуучуудын асуудал эрхэлсэн байгууллагаас их, дээд сургууль, судалгааны байгууллагын эрдэмтэн судлаачдын дунд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулан, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

4.2.3.3. Инновацийг гарааны бизнестэй холбох, хөрөнгө босгох, хөгжлийн болон нийгэм, хамт олны төсөл боловсруулж, хөрөнгө оруулагчдыг татах, эко систем дэх гарааны бизнесийг хөгжүүлэх мэдлэг, туршлага солилцох ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна.

4.2.3.4. Шинэ санаа, өндөр технологи, инноваци, бүтээл нь салбарын, үндэсний болон олон улсын хэмжээнд үнэлэгдсэн залуучуудын эн тэргүүний хэрэгцээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд хувийн хэвшлийн манлайлагчдыг дайчлана.

4.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй, ээлтэй болгон сайжруулна.

4.3.1.1. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ болон салбарын хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулах зорилгоор жил бүр үндэсний болон орон нутгийн хэмжээнд ажил, мэргэжлийг эрэлттэй байдлаар нь шинэчлэн жагсааж, олон нийтэд мэдээлнэ.¹⁰

4.3.1.2. ЕБС төгсөгчдөд мэргэжил сурталчлах, мэргэжлийн боловсрол олгох сургууль болон гадаадад сургууль төгсөгчдийн дунд хөдөлмөрийн яармаг зохион байгуулах ажлыг жил бүрийн хичээлийн жилийн эхэнд болон эцэст хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.¹¹

4.3.1.3. их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдад мэргэжлийн ялгамжтай тэтгэлэг олгох зохицуулалтыг бий болгоно. Хэрэв оруулах бол боловсрол дээр оруулах

4.3.1.4. ажилгүйдлийн даатгалын сангаас олгох сургалтын зардлыг нэмэгдүүлж, ажилгүй залуучуудад мэргэжил эзэмших, ур чадвараа сайжруулах боломжийг бүрдүүлнэ.

4.3.1.5. хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн залуучуудыг гадаад улс орнуудад дадлагажуулах хэрэгцээ, мэргэжил, ур чадварын чиглэлийг тогтоодог болно.

⁹ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.7 заалтыг үндэслэв

¹⁰ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.8 заалтыг үндэслэв

¹¹ ЗГ-ын 2016 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн монголчууд” хөтөлбөрийн 6.2.5. заалтыг үндэслэв.

4.3.2. Төрөл бүрийн салбарт залуучууд албан ёсны хөдөлмөр эрхлэхэд тухайн салбар, орон нутгийн байгууллагууд, ажил олгогчийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.3.2.1. хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй малчин залуучуудыг хөрвөх ур чадвар эзэмших боломжоо нэмэгдүүлэхийг нь дэмжинэ.

4.3.2.2. гадаадад өндөр мэдлэг, ур чадвар эзэмшиж, туршлага хуримтлуулсан залуучуудыг тухайн улсаасаа эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлж, мэргэжлийн сүлжээ байгуулах, мэдлэг мэдээллээ хуваалцах ажлыг нь өргөжүүлнэ.¹²

4.3.2.3. ажил олоход хүндрэлтэй болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг дадлагажуулан байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжинэ.

4.3.2.4. орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй оюутан, залуучууд хамрагдаж болох ажил мэргэжилд цагийн ажлын тогтолцоо, уян хатан ажлын цагийг нэвтрүүлэх талаар гадаад орны туршлагыг ажил олгогчид хүртээмжтэй болгоно.¹³

4.3.2.5. аж ахуйн нэгжид хүний нөөцийг төлөвлөх, зохицуулах арга зүйг хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.

4.3.2.6. ажлын байран дахь бэлгийн дарамт, зүй бус харилцаа, ялгаварлан гадуурхалт, тэнцвэртэй бус ачааллыг шийдвэрлэж зохицуулах, урьдчилан сэргийлэх талаар гарын авлага, санамж, мэдээллийг байгууллагын анхан болон дунд шатны менежерүүд, шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад хүргэнэ.

4.3.2.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хөдөлмөр зуучлалыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллага, залуучуудын хөдөлмөрийн биржтэй хамтран тогтвортой хэрэгжүүлнэ.¹⁴

4.3.2.8. нийслэлээс хөдөө орон нутаг руу суурьшиж, тогтвортой ажиллах залуучууд, сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах, нийгмийн асуудалд нь дэмжлэг үзүүлэх талаар орон нутгийн төр, захиргааны, иргэдийн төлөөллийн, хувийн хэвшлийн байгууллагын гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлнэ.¹⁵

4.3.3. Залуучуудын сонголтоороо хөдөлмөр эрхлэх, гарааны бизнесээ эхлэх, сайн дурын ажлыг нь дэмжих макро түвшний таатай орчин бүрдүүлнэ.

4.3.3.1. залуучуудын ажилгүйдлийг бууруулах макро эдийн засгийн, үүний дотор төсөв, санхүү, мөнгөний бодлого болон ногоон ажлын байрны бодлогын арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

4.3.3.2. залуучуудад олноор нь ажлын байр бий болгож байгаа ажил олгогч залуучуудыг хөдөлмөр зуучлал, худалдан авалт, татварын бодлогоор дэмжинэ.¹⁶

4.3.3.3. гарааны бизнес эрхлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн залуучуудын шинэлэг санал, оюуны бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлж, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулна.

4.3.3.4. залуучуудын сайн дурын ажлыг ажлын туршлагад тооцох, хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнд үйлчилгээ үзүүлэх залуучуудын сайн дурын ажлыг хөхиүлэн дэмжинэ.¹⁷

¹² Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.5 заалтыг үндэслэв

¹³ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.9 заалтыг үндэслэв

¹⁴ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.1 заалтыг үндэслэв

¹⁵ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.7 болон 12.1.5 заалтыг үндэслэв

¹⁶ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.2 заалтыг үндэслэв

¹⁷ ЗГ-ын 2015 оны 4-р тогтоолоор батлагдсан "Хотжилт ба эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөрийн 4.4.7 заалтыг үндэслэв

4.3.3.5. аутсорсинг, цахим ажил үйлчилгээ эрхлэх зэргээр залуучууд орлогоо нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.¹⁸

4.3.3.6. залуучуудад бизнесийн санаа олох, түүнийгээ хөгжүүлэх албан ба албан бус бүтцийг дэмжинэ.

4.4. Тогтвортой хөгжилд залуучуудын оролцох оролцоог сайжруулах зорилтын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. Тогтвортой хөгжилд хувь хүн, бүлгийн оролцоог чиглүүлэх ойлголт мэдлэгийг залуучуудад төлөвшүүлнэ.

4.4.1.1. залуучуудад өөрийгөө хөгжүүлэн, гэр бүл, нийгмийн амьдрал, улс орны хөгжилд оролцож, Монгол улсаа дэлхийн хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүн байлгахын төлөө хариуцлагатай иргэн болж төлөвшихийн ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

4.4.1.2. даяаршил, олон соёлын нөлөө бүхий орчин, амьдралын хэв маягт өсч хүмүүжсэн Монгол залуучууд төрөлх хэлээ сурах, түүх, ёс заншил, уламжлалт соёлоо танин мэдэхэд чиглэсэн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.¹⁹

4.4.1.3. залуучуудын сонгуулийн идэвхийн талаар судалгаа хийж, түүнд үндэслэн улс төрийн оролцооны соёлыг төлөвшүүлэх ажлыг насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөрийн тогтолцоотой уялдуулна.²⁰

4.4.1.4. хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сонгох, сонгогдох эрхийг хангах, мэдээлэл өгөхдөө тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн арга хэлбэр, технологийн дэвшлийг ашиглана.

4.4.2. Залуучуудын эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах, бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, хянаж үнэлэхэд иргэний нийгэм, залуучуудын оролцоог хангана.

4.4.2.1. залуучуудын нийгэм, соёл, улс төр, эдийн засаг, иргэний идэвхтэй оролцоог төлөвшүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, төлөөллийн байгууллагатайгаа харилцах, залуучуудын асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх болон төсөв хуваарилахад хяналт тавих ажилд оролцоог нь хангана.

4.4.2.2. төрийн байгууллагын захиалгат судалгаанд олон нийт, залуучуудын асуудлаар мэргэшсэн төрийн бус байгууллага, залуучуудын саналыг тусгах, үр дүнг нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад түгээж, бодлого, хөтөлбөр, төсөлд тусгаж хэвшүүлнэ.

4.4.2.3. залуучуудын төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлж, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг залуучуудад нээлттэй болгоно.²¹

4.4.2.4. нийгмийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай залуучуудын оролцоог тэдний үүсгэл санаачилга, эрх ашгийг хамгаалах зорилгоор байгуулагдсан өөрийн удирдлагын байгууллагыг нь оролцуулах замаар хангана.

4.4.2.5. энэхүү Үндэсний хөтөлбөр болон залуучуудын хөгжлийн төлөө бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, төрийн бус байгууллагуудын талаарх мэдээлэл, төсөв, санхүүгийн тайлан мэдээг олон нийт, залуучуудад ил тод, нээлттэй хүргэх үүднээс үндэсний мэдээллийн нэгдсэн сан ажиллуулна.

¹⁸ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.4 заалтыг үндэслэв

¹⁹ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.3.3 заалтыг үндэслэв

²⁰ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.4. заалтыг үндэслэв

²¹ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.2 болон 13.1.2 заалтыг үндэслэв

4.5. Залуучуудад нийгмийн дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. Байнгын орон сууцтай болохоос өмнө залуучууд, залуу гэр бүлийн орон байрны хэрэгцээнд нь дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

4.5.1.1. хямд өртөгтэй, чанартай орон сууцны төслийг амжилттай хэрэгжүүлж буй байгууллагуудын туршлага солилцох нээлттэй арга хэмжээнд залуу гэр бүл, залуучууд олноор ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг өргөнөөр оролцуулах маркетингийг хэрэгжүүлнэ.

4.5.1.2. орон байр худалдан авах боломжгүй эсвэл түр хугацаагаар амьдрах хэрэгцээтэй залуучуудад зориулж хямд түрээсийн болон нийтийн байр барих ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

4.5.2. Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлж, хөгжүүлэхийн төлөө сайн үйлсийн ажлыг тогтвортой явуулж буй залуучуудын санаачилга, үйл ажиллагааг дэмжинэ.

4.5.2.1. залуучуудын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж, тогтвортой ажиллаж байгаа төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулах байр, газартай болоход нь орон нутгийн төр захиргааны байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.

4.5.2.2. бүх шатны боловсролын байгууллага, дотуур байрны ажилтнуудыг үндэсний болон бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурагчидтай харилцах, ажиллах ур чадвар олгох сургалтыг тодорхой хугацаанд мэргэжлийн байгууллага, холбоодын тусламжтай зохион байгуулна.

4.5.2.3. хүчирхийлэлд өртсөн залуучуудыг илрүүлэх, зөрчигдсэн эрхийг нь сэргээх, хамтарсан багийн үйлчилгээг олон нийтэд мэдээлэх, нийгмийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай залуучуудыг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, хамгаалахад сайн дураар ажиллах залуучуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлнэ.²²

4.5.2.4. хорих ял эдэлж буй залуучуудыг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангид нийгэм, эрх зүй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг радиогийн нэвтрүүлэг, аудио болон видео, цахим сургалт, зөвлөгөө өгөх замаар хэрэгжүүлнэ.²³

4.5.2.5. хүн ам ихээр төвлөрсөн нутаг дэвсгэрийн залуучуудыг оролцуулан гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газруудын зураглал хийж, камержуулна.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллага
		Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт		
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт							
Зорилго: Хөтөлбөрийн зорилго нь залуучуудыг нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх замаар өөрийн, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх, үүргээ ухамсарладаг өрсөлдөх чадвартай иргэн болоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино.							
Өрсөлдөх чадварын Монгол улсын зэрэглэл	Оноо	2016	3.8	2020		World Economic Forum	Үндэсний хөгжлийн газар

²² Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 15.1.4 заалтыг үндэслэв

²³ “Залуучуудын үндэсний бодлогыг боловсруулах чиглэлээр телевизийн болон радио нэвтрүүлгээр дамжуулан явуулсан хэлэлцүүлгийн материалд хийсэн дүн шинжилгээ” 14 дэх тал, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, УБ., 2014; Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн 10.1.5 болон 15.1.3 заалтыг үндэслэв

Хүний хөгжлийн индекс		2016	0.734	2020		Үндэсний Статистикийн хороо	ХНХЯ
Зорилт 1: Залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.							
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	хувь	2016	37.3	2020		Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ
15-19 насны 1000 хүнд ногдох охидын төрөлтийн түвшин	түвшин	2016	33.1	2020		Хүн амын ердийн хөдөлгөөний мэдээ	ҮСХ
10 000 хүнд ногдох эмнэлгийн ажилтны тоо, (Их эмч/ сувилагчийн тоогоор)	түвшин	2016	32.4/ 61.2	2020		Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ
15-34 насны 10 000 хүнд ногдох халдварт бус өвчний тархалт	түвшин	2016	13.41	2020	10.5	Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ
15-34 насны 10 000 хүнд ногдох бэлгийн замын халдварын тархалт	түвшин	2016		2020		Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ
10 000 хүн амд ногдох сэтгэцийн эмчийн тоо, аймаг, дүүргээр ²⁴	түвшин	2015	0.2	2019	0.3	Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ
15-24 насны залуучуудын тамхины хэрэглээний түвшин	хувь	2013	Эмэгтэй/ Эрэгтэй			Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	ҮСХ
15-24 насны залуучуудын архины хэрэглээний түвшин	хувь	2013	Эмэгтэй/ Эрэгтэй	2018		Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	ҮСХ
15-24 насны залуучуудын нас баралтын түвшин, шалтгаанаар	хувь						ЭМЯ
Сүүлийн 4 долоо хоногт сэтгэлзүйн хямралтай байсан 15-24 насны залуучуудын эзлэх хувь							
Зорилт 2: Боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулна.							
Суурь боловсрол эзэмшсэн 18-24 насны залуучуудын эзлэх хувь	Хувь						ҮСХ
Дээд боловсрол эзэмшсэн 30-34 насны залуучуудын эзлэх хувь	хувь						ҮСХ
Дунд болон түүнээс дээш боловсролтой 20-24 насны залуучуудын эзлэх хувь	Хувь						ҮСХ
ЕБС-ийн ахлах ангид суралцагчдын хүйсийн харьцаа							БСШУСЯ
Дээд боловсролд хамрагдаж буй оюутнуудын хүйсийн харьцаа		2015 /2016		2020			БСШУСЯ
Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал		2014 /2015	59.6 ²⁵	2020		Төгсөгчдийн судалгаа	ХНХЯ
Зорилт 3: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.							
15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин	Хувь	2016	25.1	2020		Ажиллах хүчний судалгаа	ҮСХ
Залуучуудын ажилгүйдлийн харьцаа						Ажиллах хүчний судалгаа	ҮСХ
15-24 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	2016 оны эцэс	22.1	2020		Ажиллах хүчний судалгаа	ҮСХ

²⁴ Эрүүл мэндийн үзүүлэлт- 2015, Эрүүл мэндийн хөгжлийн төв, www.chd.mohs.mn, Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний хоёр дахь хөтөлбөр

²⁵ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа- 2015: 2012-2013 оны хичээлийн жилд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа. УБ хот

Хөдөлмөр эрхэлж буй залуучуудад хувиараа хөдөлмөр эрхэлж буй 20-29 насны залуучуудын хувь							
Хөдөлмөрийн түр хугацааны гэрээгээр хөдөлмөр эрхэлж буй 20-29 насны залуучуудын эзлэх хувь							
Гарааны бизнес эрхлэх, залуучуудын сайн дурын ажлыг дэмжих эрх зүйн бичиг баримтын тоо	тоо	2016 оны эцэст	Үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа нийт хууль, тогтоомж ийн тоо	2020			ХНХЯ
Зорилт 4: Тогтвортой хөгжилд залуучуудын оролцох оролцоог сайжруулна.							
Төрийн байгууллагаас залуучуудын төрийн бус байгууллагатай гэрээ байгуулсан тоо		2016		2020		Салбаруудын тайлан мэдээнээс цуглуулна	ХНХЯ
Орон нутгийн, УИХ, ерөнхийлөгчийн сүүлийн сонгуульд 18-30 насны залуучуудын оролцсон байдал		2016		2020			СХХ
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа залуучуудын санаачилсан төсөл, хөтөлбөрийн тоо		2017 оны эцэст	.	2020		Аймгуудын тайлангаас нэгтгэнэ	ХНХЯ
Залуучуудын талаар шийдвэр гаргах Үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт оролцсон залуучуудын ТББ-ын оролцооны хувь (залуучуудын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын дотор эзлэх хувиар тооцож гаргана.)		2017 оны эцэст		2020		Салбаруудын тайлан мэдээнээс цуглуулна	ХНХЯ
Зорилт 5: Залуучуудад нийгмийн дэмжлэг үзүүлнэ.							
Байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь	Хувь	2010 оны ХАО СТ	53.6				
Ядуу өрхөд амьдарч буй 15-34 насны залуучуудын эзлэх хувь	хувь	2016				ӨНЭЗС	ҮСХ
Залуучуудад дэмжлэг үзүүлэхээр нийгмийн даатгал болон халамжийн томоохон хууль тогтоомжид орсон өөрчлөлт		2016 оны эцэс	Хуулийн агуулгад экспертийн дүн шинжилгээ хийж гаргана.				

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.3. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж;

6.1.4. бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан удирдлага

зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

7.3. Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг бүх шатны Засаг дарга/Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт – шинжилгээ, үнэлгээ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран жил бүр хийнэ.

8.2. Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга, холбогдох байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран жил бүр хийнэ. Бүх шатны Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

8.3. Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлд танилцуулна.